



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 93

Номгон

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн  
хурлын дэргэд “Мини парламент” байгуулж,  
ажиллах журмыг батлах тухай

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2019 оныг “Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжлийн жил” болгон зарласантай холбогдуулан тухайн жилд зохион байгуулах ажлын хүрээнд хүүхдийн зөв хүмүүжил, төлөвшлийг бий болгох, соёлтой мэтгэлцэх, мэтгэлцээний ур чадварыг хөгжүүлэх, мэдлэг туршлагаа нэмэгдүүлэх, хүүхдийн бие даасан бүтээлч сэтгэлгээ, чадавхийг хөгжүүлэх, хүүхдүүдийн дунд тулгамдаж буй асуудлыг өөрсдийнх нь оролцоотой шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд хүүхдийн өөрөө удирдах байгууллага болох “Мини парламент”-ийг байгуулсугай.
2. Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд “Мини парламент”-ийг байгуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт зөвлөж, Засаг дарга нарт даалгасугай.
3. “Мини парламент”-ын ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР



## “МИНИ ПАРЛАМЕНТ”-ИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд ажиллах хүүхдийн өөрөө удирдах байгууллага болох “Мини парламент”-ийн үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөн ажиллана.

1.2. “Мини парламент”-ийн зорилго: Хүүхдийн зөв хүмүүжил, төлөвшлийг бий болгох, соёлтой мэтгэлцэх, мэтгэлцээний ур чадварыг хөгжүүлэх, мэдлэг туршлагаа нэмэгдүүлэх, хүүхдийн бие даасан бүтээлч сэтгэлгээ, чадавхийг хөгжүүлэх, хүүхдүүдийн дунд тулгамдаж буй асуудлыг өөрсдийнх нь оролцоотой шийдвэрлэхэд оршино.

1.3. “Мини парламент” нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, тэдгээртэй холбогдох бусад хууль, тогтоомжууд болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

### Хоёр. “Мини парламнет”-ийн бүтэц, бүрэлдэхүүн

2.1. Сум тус бүрийн “Мини парламент”-ийн төлөөлөл нэг сурагч, аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийг төлөөлсөн сурагчдаас бүрдсэн 25-30 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд ажиллана.

2.2. Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд тухайн сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас бүрдсэн “Мини парламент” ажиллана.

2.3. “Мини парламент”-ийн бүрэлдэхүүнд анги хамт олноо манлайлан, сурлагын амжилт гаргаж, цаашид бусаддаа үлгэр дуурайлал болохуйц, өөрийгөө зөвөөр илэрхийлэх чадвартай сурагчдыг сайн дурын үндсэн дээр оруулна.

2.4. “Мини парламент”-ийн даргыг гишүүдийн дотроос олонхийн саналаар сонгоно

### Гурав. “Мини парламент”-ийн гишүүдийн эрх, үүрэг

3.1. Хүүхдүүдийн өмнө тулгарч буй асуудлыг дэвшүүлэн тавьж, шийдвэрлүүлэх

3.2. Монгол ёс уламжлалыг бусдад үлгэрлэн таниулж, зөв төлөвшлийг бий болгох

3.3. Байгаль орчноо хайрлан хамгаалах талаар үе тэнгийн хүүхэд, багачуудад мэдээ, мэдээлэл хүргэх

3.4. Бусад ямар төрлийн асуудлаар асуудал дэвшүүлж, санал гаргаж болно  
Дөрөв. “Мини парламент”-ийн үйл ажиллагаа

3.1. “Мини парламент”-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.2. Улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ээлжит бус хурлыг гишүүдийн олонхийн санаачилгаар зарлан хуралдуулж болно.

3.3. Хуралдаанаас зөвлөмж гаргах бөгөөд зөвлөмжийг гишүүдийн нэгдмэл саналыг үндэслэх зарчмыг баримтлана. Гишүүд нэгдмэл саналд хүрэхгүй тохиолдолд хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй гишүүдийн саналаар шийдвэрлэнэ.

3.4. Зөвлөмж нь санал, дүгнэлт хэлбэртэй байж болно. Зөвлөмжид дарга, хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

Тав. Бусад зүйл

Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Зөвлөлийн гишүүдийн олонхийн санаачилгаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн баталгаажуулна.